

Гэтэлгэгчийн маань хад

Далын

Ахлагч Вилфорд В.Андерсен

Түүний зарлигуудыг сахидаг хүмүүс итгэл найдвараараа өсч хөгжинө гэдгийг би гэрчилж байна. Амьдралын бүх хүнд сорилт бэрхшээлийг даван туулах хүч чадал тэдэнд өгөгдөх болно.

Олон жилийн өмнө би гэр бүлтэйгээ Иллиной муж улсын Науву хотод айлчилсан юм. Тэнд анхны Гэгээнтнүүд орогнох газар хайн ирцгээжээ. Өсөн нэмэгдэж буй мөрдлөг хавчлагын улмаас тэдний олонх нь гэр орон, фермээ мөн зарим нь хайрт хүмүүсээ алдсан байлаа. Үнэндээ хавчлага дэндүү хэрцгий хүнд байв. 1846 он гэхэд тэд дахин албадлагаар гэр орноо орхих болсон билээ. Энэ удаа тэд яс янгинам хөхөө өвлийн хүйтнээр явах болсон. Тэд үл мэдэгдэх ирээдүй тийш чиглэн Миссиппи мөрний тэсгим хүйтэн усыг гатлахаар Парли гудамжинд тэрэгнүүдээ эгнүүлэн ээлжээ хүлээн зогсож байлаа. Хүмүүсийн хүнд нөхцөл байдлынх нь талаар бодон Парли гудамжинд бид зогсож байхдаа зовж зүдэрсэн Гэгээнтнүүдийн өдрийн тэмдэглэлээс эш татан сийлсэн модон тэмдгүүдийг хашаанд хадсан байхыг олж харсан юм. Эдгээрийг уншиж үзэхэд гайхал төрүүлсэн зүйл нь аргаа барсан цөхрөлийн үгс биш, харин итгэл найдвар, үүрэг хариуцлага, баяр баяслын үгс байж билээ. Тэдний үгс итгэл найдвараар дүүрэн байсан бөгөөд энэхүү итгэл найдварыг 1846 оны 2 дугаар сард бичсэн Сара ДиАрмон Ричийн дараах өдрийн тэмдэглэлийн хэсгээс харж болно. Ийм аяллыг өвлийн хүйтэнд эхлэх нь үхлийн занга уруу орох мэт санагдаж болно. Гэвч бид итгэлтэй байсан юм... мөн бидний чөлөөлөгдөх өдөр ирсэнд баяссан юм”¹ хэмээн тэмдэглэлд өгүүлжээ. Эхэн үеийн Гэгээнтнүүд орон гэргүй байсан ч итгэл найдвараар дүүрэн байжээ. Зүрх сэтгэл нь эмтэрсэн ч, сүнслэг байдлаараа хүчтэй байлаа. Тэд итгэл найдвар болон түүнээс ирдэг адислал болох амар амгалан, аз жаргал нь нөхцөл байдлаас хамаардаггүй болохыг мэдсэн юм. Жинхэнэ найдварын эх булаг нь итгэл, бидний хувьд амьдралаа төлөвшүүлвэл зохих тэрхүү цорын ганц үнэн суурь болох Их Эзэн Есүс Христ болон Түүний хязгааргүй Цагаатгалд итгэх итгэл юм.

Өнөөдөр өөр нэгэн бүлэг анхдагч нарын энэ чухал зарчмыг үлгэр жишээгээрээ харуулж байна. Нэгдүгээр сарын 12-ны мягмар гарагт Гайтид асар их гамшиг учруулсан газар хөдлөлт боллоо. Энэ газар хөдлөлтөд нийслэл Порт-ау-Принц хот сүйрчээ. Газар хөдлөлтийн гамшгийн үр дагавар нь маш сэтгэл үймрүүлсэн бөгөөд 1,000,000 хүн орон гэргүй болж, 200,000 гаруй хүн амь насаа алдсаныг мэдээлжээ.

Өмнө нь хэзээ ч болж байгаагүйгээр дэлхий даяар нэгдэн туслах үйл ажиллагаа өрнөж байх үед өөр нэгэн гайхамшигтай аврах үйл ажиллагаа Порт-ау-Принцэд зохион байгуулагдаж байлаа. Энэ үйл ажиллагааг санваарын загварын дагуу Гайти дахь Сүмийн удирдагчдаас бүрдсэн хороо сүнсний удирдамжийн дагуу зохион байгуулсан юм. Энэ хорооны гишүүдийн дунд хоёр гадасны ерөнхийлөгч, хоёр гадасны Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч, мөн 30 настайдаа Гайтийн Порт ау Принц номлолын бүрэн цагийн 74 номлогчийг удирдаж буй Номлолын ерөнхийлөгч нар байлаа. Түүний бүх номлогч Гайтийн иргэн бөгөөд гайхамшигтай нь энэхүү аймшигт газар хөдлөлтөнд тэдний нэг нь ч гэмтэж бэртээгүй. Сүнсээр удирдагдсан орон нутгийн удирдагчдын гарт Сүмийн бүх нөөц, түүний дотор та бүхний өгөөмөр хандивыг хүлээлгэн өгсөн юм. Энэхүү хандивт Гайтийн ард түмэн туйлын их талархаж байгаа нь лавтай. Энэ хорооны удирдлага дор Бүгд Найрамдах Доминикан Улсаас ачааны олон машин дүүрэн хүнсний зүйл тэр даруй иржээ. Газар хөдлөлт болсноос хойш хэдхэн хоногийн дотор олон онгоцоор дүүрэн хүнс, ус цэвэршүүлэх төхөөрөмж, майхан, хөнжил, эмнэлгийн тоног төхөөрөмж, эм хэрэгсэл, эмч нарын баг ирсэн байна.

Порт-ау-Принцэд болон үүний ойролцоо сүмийн нийтдээ 9 байр байдгаас бараг нэг нь ч гэмтээгүй ажээ. Энэ бол бас нэг гайхамшиг юм. Газар хөдлөлтийн дараагийн долоо хоногт эдгээр байрууд Гайтийн 5000 гаруй иргэдийн хоргодох газар болж, хоол хүнс болон ус түгээж, эмнэлгийн тусламж үзүүлж байлаа. Үндсэн хэрэгцээ нь хангагдаж, үймээн самуун намдаж эхэлжээ.

Гайтийн итгэлтэй Гэгээнтнүүд асар их гай зовлон амссан ч ирээдүйдээ итгэх итгэл найдвараар дүүрэн байна. 1846 оны эхэн үеийн анхдагчуудын нэгэн адил тэдний зүрх сэтгэл шимшрэн өвдсөн ч сүнслэг байдал нь хүчтэй байна. Эдгээр хүмүүст мөн бидэнд найдвар, аз жаргал, баяр баясгалан нь нөхцөл байдлаас бус харин Их

Эзэнд итгэх итгэлээс ирдгийг зааж байна.

Бошиглогч Мормон тэсэхүйеэ бэрх нөхцөл байдлыг биеэрээ туулсан бөгөөд доорх сургаалыг ойлгон түүнийгээ тод томруунаар заадаг байжээ :

“Мөн тэрчлэн, хайрт ах дүүс минь, би та нарт найдварын талаар ярьмаар байна... Болгоогтун та нар Христийн цагаатгал[аар], . . .найдахыг би та нарт хэлье, мөн энэ нь амлалтын дагуу түүнд итгэлтэйн тань учир болой. Иймийн тул, хүмүүн итгэлтэй аваас түүнд найдвар байх нь гарцаагүй; учир нь итгэлгүйгээр ямар ч найдвар байж чадахгүй.”²

Найдвар нь Есүс Христэд итгэх итгэлээс ирдэг. Тэрээр дэлхийг аль хэдийн ялсан бөгөөд бид Түүн уруу эргэж, Түүнд итгэн,Түүнийг дагах аваас Тэрээр нүднээс урсах нулимс бүрийг арчина³ гэж амласан билээ.

Яг энэ үед аргаа барсан,сэтгэл цөхөрсөн зарим хүмүүс яаж найдварыг дахин үнэхээр олж авах вэ гэж бодож байж болно. Хэрэв та ийм хүмүүсийн нэг бол найдвар нь итгэлийн үр дүнд ирдэг болохыг санаарай. Хэрэв бид найдвартай байхыг хүсвэл эхлээд итгэлтэй болох хэрэгтэй.

Аврагчид итгэх итгэл нь зөвхөн итгэхээс илүү ихийг шаарддаг. Төлөөлөгч Иаков чөтгөрүүд ч мөн үүнд итгэдэг бөгөөд чичирдэг юм⁴хэмээн заасан байдаг. Чөтгөрүүд болон Сүмийн итгэлтэй гишүүдийн хоорондох ялгаа бол итгэлд бус харин үйлдэлд нь байдаг юм. Зарлигуудыг дагаснаар итгэл өсдөг. Зарлигуудыг дагахын төлөө бид зүтгэх хэрэгтэй. Библийн толь бичгээс бид дараах зүйлийг уншдаг

“Гайхамшгууд нь итгэлийг бий болгодоггүй харин Есүс Христийн сайн мэдээнд дуулгавартай байснаар итгэл нь бий болон хөгждөг. Өөрөөр хэлбэл итгэл нь зөв шударга байдлаас ирдэг... “⁵.

Бид Бурханы зарлигуудыг дагахыг хичээж, нүглээ наманчлан мөн Аврагчийг дагахын тулд бүх хүч чадлаараа хичээхийг амласан үед цагаатгалын үр дүнд бүх

зүйл сайн сайхан болно гэдэгт илүү итгэлтэй болдог. Анхдагч эцэг эхчүүдийн маань хэлснээр, “санаа зовох хэрэггүй”⁶ зүйлүүдээс биднийг холдуулагч Ариун Сүнс энэхүү мэдрэмжийг бидэнд баталж өгдөг билээ. Бид зовлон зүдгүүртэй ч сайн сайхан байдлын мэдрэмжээр дүүрэн байдаг. Анхдагчуудтай “бүх зүйл сайн байна”⁷ гэж дуулмаар санагддаг.

Сэтгэлээр унах нь бодитой байж болохыг би үгүйсгэхийг хүсэхгүй байна. Чадварлаг мэргэжилтнээс зөвлөгөө авах нь зарим хүмүүсийн хувьд сэтгэл санааны дарамтаасаа салах зам байж болно. Гэвч бидний ихэнхийн хувьд авралын төлөвлөгөөг Зохиогч Нэгэнд итгэл найдвараа тавьж, Энхийн Жононд итгэх итгэлээ хөгжүүлснээр гай зовлон, айдас хүйдэс биднээс арилж, аз жаргал, амар амгалан ирдэг билээ.

Саяхан дотны нэгэн найз маань хорт хавдраас болж өөд болсон юм. Тэр өөрөө ч гэрийнхэн нь ч агуу итгэлтэй хүмүүс байв. Энэ хэцүү цаг үед тэд ямар их итгэлтэйг харах нь сүнслэг нөлөө үзүүлдэг байлаа. Тэднийг өргөж, бат бөх суурьтай болгосон итгэл болон дотоод сэтгэлийн амар амгалан байдлаар тэд ямагт дүүрэн байдаг байлаа. Тэдний зөвшөөрөлтэйгээр, Аавыгаа өөд болохоос хэдхэн хоногийн өмнө бичсэн гэр бүлийнх нь нэг гишүүний захидлаас уншихыг хүсэж байна. Зөвшөөрлийг нь авсан юм:

“Сүүлийн хэдэн өдөр бүр хэцүү байлаа... Урд шөнө бид аавынхаа орыг тойрон зогсож байтал Их Эзэний Сүнс мэдрэгдэж, биднийг үнэхээр тайвшруулсан билээ. Бид сэтгэл тайван байна... Энэ бол бид бүгдийн хувьд өмнө нь хэзээ ч тохиолдож байгаагүй тийм хүнд зүйл байлаа. Гэвч бид гэр бүлээрээ дахин хамтдаа амьдрах болно гэж Тэнгэр дэх Эцэг маань амласныг мэддэг учраас сэтгэл тайван байна. Аавд минь хийж болох өөр ямар ч эмчилгээ байхгүйг эмч мэдэгдэхэд, аав бидэн уруу төгс итгэлтэйгээр харж, “Авралын төлөвлөгөөг эсэргүүцсэн хүн энэ өрөөнд байна уу?” гэж зоригтойгоор асууж билээ. Бид эсэргүйцдэггүй ээ, харин энэ төлөвлөгөөнд төгс итгэхийг заасан аав, ээж хоёрынхоо төлөө талархаж байна.”

Бүх зовж зүдэрсэн, эмгэнэж гашуудсан хүмүүст мөн яг одоо амьдралдаа зовлон бэрхшээлтэй тулгарсан болон ирээдүйд тулгарах бүх хүмүүст би хандан ярьж

байна. Миний энэ захиас сэтгэл нь үймэрч, айж түгшсэн, гутарч цөхөрсөн бүх хүмүүст хандсан юм. Миний захиас бол бидний Хайрт Эцэг дэлхийн эхлэлээс хүүхдүүддээ тайвшруулах зөвлөгөөг үргэлж өгсөөр ирснийг сануулах дохио юм.

“..., Санагтун, Бурханы Хүү, Христ болох, бидний Гэтэлгэгчийн хадан дээр та нар сууриа тавих ёстойг санагтун; иймээс чөтгөр хүчит салхиа, тийм ээ, хуй салхин дайралтаа илгээхэд, тийм ээ, түүний бүхий л мөндөр мөн хүчит шуурга та нар дээр нүдэхэд, энэ нь та нарыг зовлонгийн хийгээд төгсгөлгүй халаглалын ангал тийш доош чирж дийлэх хүчгүй байх болно, та нар дээр нь босгогдсон, бат бөх суурь дээр, хүмүүн нь үүний дээр баривал унах аргагүй болох хадны учир болой.”⁸

Би Түүний дэлхийг ялсан гэдгийг, мөн Тэрээр биднийг гарынхаа алган дээрээ сийлсний ⁹ учир биднийг хэзээ ч мартахгүй бас орхихгүй гэдгийг гэрчилж байна. Түүний зарлигуудыг дагах хүн бүрийн итгэл, найдвар өсөх болно. Тэдэнд амьдралын бүхий л зовлонг даван туулах дийлэх хүч өгөгдөх болно гэдгийг би гэрчилж байна. Тэгээд тэд бүх оюун ухаанаас дээгүүрх Бурханы амар амгаланг мэдрэх болно.¹⁰

Есүс Христийн нэрээр, амен.

ТЭМДЭГЛЭЛ

1. Remembrances of Sarah DeArmon Pea Rich, *The Iowa Trail*, x. 173-4.
2. Моронай 7:40-42.
3. Илчлэлт 7:17.
4. Иаков 2:19.
5. Библийн толь бичиг, “Итгэл”.

8. Хиламан 5:12.

9. 1 Нифай 21:16.

10. Филиппой 4:7